



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/107

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 7 дугаар зүйлийн 7.1, 22 дугаар зүйлийн 22.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Аюулгүй гамшигт тэсвэртэй хотыг бий болгох нь” санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээнд “Гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх аргачлал”-ын дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн гамшгийг тэсвэрлэх чадавхын үнэлгээний дүнг нэгтгэн 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Б.Алтанбадралт)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 07-ны өдрийн
А/107 дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:	Т.Дэлгэрсайхан	- Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд:	Ц.Цогтбаяр	- Ховд хотын захирагч бөгөөд Жаргалант сумын Засаг дарга
	Г.Нэргүй	- Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа
	П.Бямбадорж	- Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Улсын хяналтын байцаагч, хошууч
	Г.Ганжаргал	- Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, ахлах дэслэгч
	Б.Одгэрэл	- Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын Ангилалын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, ахмад
	Б.Түмэндэмбэрэл	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Д.Эрдэнэбат	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	З.Өмиртай	- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын хэлтсийн дарга, аймгийн ерөнхий архитектор

- Р.Цэцэгмаа - Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Геодези зураг зүй хариуцсан мэргэжилтэн
- Д.Нямтулга - Мэргэжлийн хяналтын газрын Барилга техникийн хяналтын улсын хяналтын байцаагч
- Б.Отгонтөмөр - Ус цаг уур орчны шинжилгээний төвийн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан зэвсгийн инженер
- Ц.Очирбат - Статистикийн хэлтсийн Хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн
- Нарийн бичгийн дарга: С.Цогзаяа - Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч